

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Төмөржил	Дугаар	L068
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Матад сум
Төрсөн газар	Матад сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хошуу хийд	Сүм хийдийн дугаар	ДОМТ 052
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 21	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Матад сумын Хошуу хийд

Танай нутагт ямар ямар хийд байсан бэ?

Баруун хөшөөгийн хийд гэж байсан шүү. Баян-Өлзийн ердөө наахна.

Тэр ямар хийд байсан бэ?

Энэ хийдүүдээс тасарсан бага хурал байсан. Алтан-Очирт, Мэргэн хамба гэж дандаа тодорсон хутагтууд. Хошуу хийд гэж энэ баруун дор адагт байгаа хийд мөн. Жаргалант Матад гэж 2 сум байсан. Манай хошуу хийд бол энэ баруун урд байсан. Ёстой том хийд байсан. Би өрөө энд төрсөн. Манай аав тэнд суудаг байсан. Данзан гэдэг хүн байсан.

Хошуу хийдийн төвд нэр нь юу гэдэг байсан бэ?

Мэдэхгүй.

Ойролцоох газруудын нэр?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Адаг гэж бий. Овоон гол. Адагт л байгаа хийд дээ. Одоо бүр том суварганы том шороо бий. Зүүнтээ хоёр хийд байгаа Арынх нь Алтан-Очиртынх, өврийнх нь Мэргэн бандидын хийд. Аржаргалантын хийд гэдэг нь Арын хамбын хийд.

-Шар овооны хурал гэж дуулсан уу?

Тэрийг чинь мэдэхгүй юм.

-Шар энгэр гэдэг газар байна уу?

Баруунтаа бий. Хошуу хийд чинь Шар энгэрийн наана байгаа.

-Энд Хадан хөв гэж газрын нэр байх юм?

Тэгвэл тэр Хадан хөвийн урд бас Шар овоо гэж бий. Тэр бол Зүүн Матадынх. Тэрийг би сайн мэдэхгүй байна.

-Тээгийн хурал гэж мэдэх үү? Тээгийн худгийн хажууд. Бор толгойн зүүн хойно. Хүн тавидаг газар байна уу?

Хошуу хийдийн тэнд хүн тавидаг байсан. Хошуу хийд Тээгийн зүүн дор л доо. Тээгийн хурал гэдэг чинь Хошуу хийд л байна даа.

- Баян- Өлзийтийн хийд гэж дуулсан уу?

Миний багад Баруун хөшөөтийн хийд гэдэг л Баян- Өлзийтийн хийд юм болов уу гэж таамаглаж байна.